ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 4-р Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/178/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Д.Дашзэвэг

Утас: 95329926 Цахим хаяг: dashzeveg_d@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ ........ 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 4
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**........ Error! Bookmark not defined.
**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** ........ 5
**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**........ 7
**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**........ 9
**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** ........ 9
**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** ........ 11
3.Аудитын тайлан ........ 12
**3.1 Ерөнхий зүйл** ........ 12
**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт** ........ 12
**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал** ........ 13
**3.4 Материаллаг байдал** ........ 13
**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга** ........ 13
**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ........ 14
**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг** ........ 14
**3.8 Аудитын гол асуудал** ........ 14
**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**........ 14
**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**........ 14
**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**........ 15
**3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол** ........ 15
4. Аудитын илрүүлэлт ........ 15
**4.1 Залруулсан алдаа** ........ 15
**4.2 Зөвлөмж** ........ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2022. 02. 25 № 289

танай ____________-ны №____________-т

АРВАЙХЭЭР СУМЫН 4 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.ШООВДОР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арвайхээр сумын 4-р Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арвайхээр сумын 4-р Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

015030578

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

| САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | | | |
|---|---|---|---|
| | | | /Төгрөгөөр/ |
| | | | |
| **Данс ы код** | **Балансын үзүүлэлт** | **Эхний үлдэгдэл** | **Эцсийн үлдэгдэл** |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **50676958.20** | **58812561** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **50676958.20** | **58,812,561.4** |
| 351 | **Түүхий эд материал** | 901536.00 | 560,536.0 |
| 35130 | **Эм боох материал** | 901536.00 | 560,536.0 |
| 354 | **Хангамжийн материал** | 49775422.20 | 58,252,025.4 |
| 35410 | **Бичиг хэргийн материал** | 1032000.00 | 601,200.0 |
| 35420 | **Аж ахуйн материал** | 2999470.00 | 3,399,170.0 |
| 35450 | **Барилгын засварын материал** | 19000.00 | 1,419,000.0 |
| 35460 | **Хүнсний материал** | 4484722.80 | 6,137,926.0 |
| 35470 | **Бусад хангамжийн материал** | 41240229.40 | 46,694,729.4 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **596784648.43** | **571578615** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **596784648.43** | **571578615** |
| **392** | **Биет хөрөнгө** | **522281348.55** | **497035975** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 530246231.42 | 530246231 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -41700712.56 | -68745687 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 46231806.50 | 46793009 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -34271904.87 | -32562151 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 57659169.00 | 56994739 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37937554.94 | -38493891 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 0.00 | 520000 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -28889 |
| 39217 | Ном | 2054314.00 | 2312614 |
| 393 | Биет бус хөрөнгө | 74503299.88 | 74542640 |
| 39301 | Програм хангамж | 1823300.00 | 1671633 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1300000.12 | -1108994 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 73980000.00 | 73980000 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **647461606.63** | **630391176** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **647461606.63** | **630391176** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **647461606.63** | **630391176** |

| | | | |
|---|---|---|---|
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | **192866788.10** | **192866788** |
| **51101** | **Өмч: - төрийн** | **192866788.10** | **192866788** |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **155812738.61** | **138742308** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 155812738.61 | 155812739 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -17070430 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 298782079.92 | 298782080 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **647461606.63** | **630391176** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

| Данс ы код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **483880700.00** | **474112526.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **0.00** | **6123924.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 0.00 | 6123924.10 |
| 120009 | Бусад орлого | 0.00 | 6123924.10 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/ | | 2070000.02 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого / бараа материал/ | | 3429300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **483880700.00** | **462489302.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 432799900.00 | 417664800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 432799900.00 | 417664800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5534000.00 | 1597402.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 1457402.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 140000.00 | 140000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 45546800.00 | 43227100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45546800.00 | 43227100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **511581272.20** | **491182956.41** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **511581272.20** | **491182956.41** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 496249683.26 | 486743128.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 341956350.00 | 334127810.00 |
| 210101 | Үндсэн цалин | 220226700.00 | 235681055.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 92398531.00 | 77677116.00 |
| 210104 | Урамшуулал | 29331119.00 | 20769639.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45149367.06 | 45374314.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31105181.85 | 31536464.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3514000.00 | 3506712.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2807938.13 | 2754949.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 701859.56 | 688762.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7020387.52 | 6887425.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32191173.00 | 36360100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3378736.00 | 3550800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26552213.00 | 29734300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2260224.00 | 3075000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3554500.00 | 3594600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 556700.00 | 539100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 786600.00 | 577000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 732300.00 | 298400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1220600.00 | 2172700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 0.00 | 7400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 26542004.60 | 22846896.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 613864.00 | 627000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 25515540.60 | 21707996.80 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 412600.00 | 511900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6116200.00 | 4087000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6116200.00 | 4087000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 263500.00 | 380000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 263500.00 | 380000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 474000.00 | 827300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 150000.00 | 827300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324000.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40002588.60 | 39145107.61 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 382100.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2462100.00 | 1266850.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 37158388.60 | 37878257.61 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 15331588.94 | 4439827.81 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3619700.00 | 2831700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3619700.00 | 2831700.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4472461.94 | 400.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4472461.94 | 400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7239427.00 | 1607727.81 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7239427.00 | 1607727.81 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-27700572.20** | **-17070430.29** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-27700572.20** | **-17070430.29** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **483880700.00** | **462489303.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **483880700.00** | **462489303.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 432799900.00 | 417664800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 432799900.00 | 417664800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5534000.00 | 1597403.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 1457402.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5394000.00 | 1.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 140000.00 | 140000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 45546800.00 | 43227100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45546800.00 | 43227100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **483577400.00** | **462489303.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **483577400.00** | **462489303.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **468245811.06** | **458049475.19** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 341856350.00 | 334127810.00 |
| 210101 | Үндсэн цалин | 220126700.00 | 235681055.00 |
| 210102 | Нэмэгдэл | 92398531.00 | 77677116.00 |
| 210104 | Урамшуулал | 29331119.00 | 20769639.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45149367.06 | 45374314.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31105181.85 | 31536464.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3514000.00 | 3506712.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2807938.13 | 2754949.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 701859.56 | 688762.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7020387.52 | 6887425.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32191173.00 | 36360100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3378736.00 | 3550800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26552213.00 | 29734300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2260224.00 | 3075000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9693600.00 | 3755650.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 459000.00 | 669650.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 863600.00 | 577000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 258300.00 | 258300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 732300.00 | 298400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7380400.00 | 1952300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 29165221.00 | 24979100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1195400.00 | 986000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 25689221.00 | 23361200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2280600.00 | 631900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6116200.00 | 10567000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 3700000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6116200.00 | 6867000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 263500.00 | 380000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 263500.00 | 380000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 474000.00 | 827301.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 150000.00 | 827300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324000.00 | 1.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3336400.00 | 1678200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 382100.00 | 332100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2954300.00 | 1346100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15331588.94** | **4439827.81** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3619700.00 | 2831700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3619700.00 | 2831700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4472461.94 | 400.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4472461.94 | 400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7239427.00 | 1607727.81 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7239427.00 | 1607727.81 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 192,866,788.10 | 298,782,079.92 | 155,812,738.61 | 647,461,606.63 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **192,866,788.10** | **298,782,079.92** | **155,812,738.61** | **647,461,606.63** |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **192,866,788.10** | **298,782,079.92** | **155,812,738.61** | **647,461,606.63** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **192,866,788.10** | **298,782,079.92** | **155,812,738.61** | **647,461,606.63** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **192,866,788.10** | **298,782,079.92** | **155,812,738.61** | **647,461,606.63** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -17,070,430.29 | -17,070,430.29 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **192,866,788.10** | **298,782,079.92** | **138,742,308.32** | **630,391,176.34** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 498211600.00 | 466634811.06 | 460891900.00 | 459283772.19 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 498211600.00 | 466634811.06 | 460891900.00 | 459283772.19 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 494586600.00 | 463015111.06 | 458059800.00 | 456452072.19 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 342216800.00 | 341856350.00 | 334144300.00 | 334127810.00 |
| 210101 | Үндсэн цалин | 220126700.00 | 220126700.00 | 229645200.00 | 235681055.00 |
| 210102 | Нэмэгдэл | 92738800.00 | 92398531.00 | 83728200.00 | 77677116.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 29351300.00 | 29331119.00 | 20770900.00 | 20769639.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47438600.00 | 45149367.06 | 46842800.00 | 45374314.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33382700.00 | 31105181.85 | 33431300.00 | 31536464.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3514000.00 | 3514000.00 | 3352900.00 | 3506712.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2811200.00 | 2807938.13 | 2682300.00 | 2754949.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 702800.00 | 701859.56 | 670600.00 | 688762.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7027900.00 | 7020387.52 | 6705700.00 | 6887425.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39430600.00 | 32191173.00 | 36360100.00 | 36360100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6614500.00 | 3378736.00 | 3550800.00 | 3550800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 29638600.00 | 26552213.00 | 29734300.00 | 29734300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3177500.00 | 2260224.00 | 3075000.00 | 3075000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4209600.00 | 4209600.00 | 3283400.00 | 3188848.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 369000.00 | 369000.00 | 369000.00 | 579650.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 863600.00 | 863600.00 | 863500.00 | 577000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 258300.00 | 258300.00 | 258300.00 | 258300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 732300.00 | 732300.00 | 316700.00 | 298400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1986400.00 | 1986400.00 | 1475900.00 | 1475498.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 50847600.00 | 29165221.00 | 24699100.00 | 24698500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1195400.00 | 1195400.00 | 705400.00 | 705400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 47371600.00 | 25689221.00 | 23361200.00 | 23361200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2280600.00 | 2280600.00 | 632500.00 | 631900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6116200.00 | 6116200.00 | 9867000.00 | 9867000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 0.00 | 3000000.00 | 3000000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6116200.00 | 6116200.00 | 6867000.00 | 6867000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 263500.00 | 263500.00 | 407600.00 | 380000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 263500.00 | 263500.00 | 407600.00 | 380000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 777300.00 | 777300.00 | 777300.00 | 777300.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 453300.00 | 453300.00 | 777300.00 | 777300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3286400.00 | 3286400.00 | 1678200.00 | 1678200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 332100.00 | 332100.00 | 332100.00 | 332100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2954300.00 | 2954300.00 | 1346100.00 | 1346100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3625000.00 | 3619700.00 | 2832100.00 | 2831700.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3625000.00 | 3619700.00 | 2832100.00 | 2831700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3625000.00 | 3619700.00 | 2832100.00 | 2831700.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 483880700.00 | 483880700.00 | 460941900.00 | 460941900.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 438193900.00 | 438193900.00 | 417714800.00 | 417714800.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 5394000.00 | 5394000.00 | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 432799900.00 | 432799900.00 | 417714800.00 | 417714800.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 45546800.00 | 45546800.00 | 43227100.00 | 43227100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 45546800.00 | 45546800.00 | 43227100.00 | 43227100.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 140000.00 | 140000.00 | 0.00 | 0.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 140000.00 | 140000.00 | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5534000.00** | **1597402.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5534000.00** | **1597402.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5534000.00 | 1597402.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5484000.00 | 566802.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 90,000.00 | 90,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,394,000.00 | 476,802.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.00 | 280600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 280,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 700000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 700,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 50000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 50,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 50000.00 | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,000.00 | |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 5534000.00 | 1597402.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5534000.00 | 1597402.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,457,402.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,394,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 140,000.00 | 140,000.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Арвайхээр сумын 4-р Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.01.07-аас 2022.01.14–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.01.16-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Д.Дашзэвэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дэлгэөнхайрхан Уул Аудит ХХК-д 2022.01.09-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Арвайхээр сумын 4-р Цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3.1-д “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” . Мөн хуулийн 4,1,1-д зааснаар “ хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага юм.”

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Арвайхээр сумын 4-р Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр сумын 4-р Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1,5 хувиар буюу 7,6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6,1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Арвайхээр сумын 4-р Цэцэрлэгийн 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 12,9 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 4,5 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 2,3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр авч, дахин үнэлгээгээр 6,1 сая төгрөгөөр нэмэгджээ.

Бараа материалын тодруулга тайлангаар 35,9 сая төгрөгийн материал төсвийн хөрөнгөөр, 3,4 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр бэлтгэж 31,2 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

Тайлант оны эцэст өр авлагагүй гарсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 1,6 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс 460,9 сая төгрөг авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

**Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 1,6 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал зардалд зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Арвайхээр сумын 4-р Цэцэрлэг нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 119 мэдээллийг 115 ил тод мэдээлсэн, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй, 4 мэдээлэл хараахан бэлэн болоогүй тул байршуулаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар албан шаардлага хүргүүлсэн бөгөөд бүрэн хэрэгжсэн байна.

### 3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 7,0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн боловч аудитын явцад шалгагдагч байгууллага дээр санхүүгийн болон санхүүгийн бус үр өгөөжөөр тооцож хүлээн зөвшөөрүүлэхээр асуудал гараагүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдэхээр асуудал гараагүй.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тавих хэмжээний алдаа зөрчил илрээгүй.

### 4.3 Албан шаардлага

**1.** Тус Цэцэрлэгийн биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа 0,7 сая төгрөгийн үнэтэй 2 санхүүгийн программ хангамж 2017 оноос хойш ашиглагдаагүй бөгөөд одоогийн байдлаар тус байгууллагын нягтлан бодогчийн компьютерын санах ойд хадгалагдаагүй байна. Энэ нь хөрөнгө бодитоор оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаагаас гадна нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5-р зүйлийн 5,1,5-д “үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**2. Засгийн газрын 2021 оны 02-р сарын 17-ний өдрийн 43 -р тогтоолын хэрэгжилтийн талаар**

Тайлант хугацаанд зочид хүлээн авахад 0,7 сая төгрөг, бэлэг дурсгалд 0,3 сая төгрөг зарцуулсан нь дээрх тогтоолын 1.3-д зочид төлөөлөгчийг хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх, ажлын дүрэмт хувцас авахад 0,2 сая төгрөг зарцуулсан нь мөн тогтоолын 1,4-д ажлын дүрэмт хувцас худалдан авахгүй байх, албан томилолтод 0,4 сая төгрөг зарцуулсан нь тогтоолын 1,5-д хурал зөвлөгөөн, газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж дотоод албан томилолтын зардлыг хэмнэх, тайлант хугацаанд спортын уралдаан тэмцээнд 0,3 сая төгрөгийг зарцуулсан нь тогтоолын 1,6-д спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх, бичиг хэргийн зардлыг 0,2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь тогтоолын 1.9-д байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагчийн хорны зэрэг зардлыг бууруулах гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Дээрх 2 албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2022 оны 06 дугаар сарын 01-ний** өдрийн дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

(сая төгрөгөөр)

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Арвайхээр сумын 4-р Цэцэрлэг | 7 | 2,8 | | | | | 2 | 2,8 | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:АУДИТОР Д.ДАШЗЭВЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 20-НИЙ ӨДӨР

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр Дугаар ААА-2022/1НН-СТА-ТИЗ/19425219/195 Арвайхээр

Арвайхээр сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгч Х.Шоовдор танаа

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын биет бус хөрөнгийн бүртгэлд байгаа 713.3 мянган төгрөгийн 2 санхүүгийн программ нь 2017 оноос хойш ашиглагдаагүй, байгууллагын нягтлан бодогчийн компьютерын санах ойд хадгалагдаагүй байгаа зөрчил илэрлээ.

Энэ нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5-р зүйлийн 5,1,5-д "үнэн зөв байх", хөрөнгө бодитоор оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан данс бүртгэлд байгаа боловч ашиглагдахгүй байгаа 2 санхүүгийн программ хангамжийг зохих журмын дагуу данснаас хасуулах арга хэмжээ авч биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 15-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгч Х.Шоовдор, нягтлан бодогч Б.Баярмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТОР Д.ДАШЗЭВЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр  Дугаар ӨВА-2022/178/НА-СТА-ТШЗ/15125219571/131 Арвайхээр

Арвайхээр сумын 4-р цэцэрлэгийн
эрхлэгч Х.Шоовдор танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд зочид хүлээн авахад 0.7 сая төгрөг, бэлэг дурсгалд 0.3 сая төгрөг, ажлын дүрэмт хувцас авахад 0.2 сая төгрөг, албан томилолтод 0.4 сая төгрөг, спортын уралдаан тэмцээнд 0.3 сая төгрөг, бичиг хэргийн зардлыг 0.2 сая төгрөг, нийтдээ 2.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", 16.5.5.-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.3-д "зочид төлөөлөгчийг хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх", 1.4-д "ажлын дүрэмт хувцас худалдан авахгүй байх", 1.5-д "хурал зөвлөгөөн, газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж дотоод албан томилолтын зардлыг хэмнэх", 1.6-д "спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх", 1.9-д "байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагчийн хорны зэрэг зардлыг бууруулах гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээрх дурдсан Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1-ийн 3-6, 1-ийн 9 дэх заалтуудыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгч Х.Шоовдор, нягтлан бодогч Б.Баярмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, О.БАТЖАРГАЛ

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР Д.ДАШЗЭВЭГ